

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Дд	Удирдах ажилтны хүлээх үүрэг.	Хэрэгжилт	Хувь
1.	2.1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах	Төрөөс Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлого, хуультогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ бүхий хэрэгжилтийг нотломжийн хамт НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/2858 дугаар бичгээр болон файлаар хүргүүлсэн. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 9 зорилтын хүрээнд 42 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2025 оны 12 дугаар 02-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт бичгээр болон файлаар хүргүүлсэн.	100
2.	2.1.2. Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах	Монгол Улсын Эрүүл мэндийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2025 онд хамтран ажиллах гэрээний 5 зорилт 39 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Хуулийн хугацаанд хүргүүлэхээр тайланг нэгтгэн ажиллаж байна.	100
3.	2.1.3. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах;	2025 оны эхний хагас жилийн байдлаар төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлэх хүрээнд: Төрийн албаны зөвлөлийн Нэр дэвшүүлэх тогтоолыг үндэслэн 11 албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагчаар, 4 албан хаагчийг хэлтэс нэгж хооронд дэвшүүлэн, 2 албан хаагчийг улсын ахлах байцаагчаар дэвшүүлэн, 5 албан хаагчийг төрийн өөр байгууллагад шилжүүлэн, төрийн үйлчилгээний албан тушаалд 3 албан хаагчийг шинээр томилсон. 3 албан хаагчийг шилжүүлэн авч, хүүхэд асрах чөлөөтэй 4 албан хаагчийн хүсэлтийн дагуу урьд эрхэлж байсан албан тушаалд томилон,	100

		нууц хамгаалах ажилтнаар ХШҮДАХэлтсийн даргыг томилж, 9 албан хаагчдад жирэмсэн амаржсан болон хүүхэд асрах чөлөө олгон ажиллаж байна. Төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах ажлын хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлан хэрэгжүүлж байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын албан хаагч нарыг Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн Цэрэнбатын Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар хичээл сургалтад хамруулан, Ёс зүйн дэд хороо, Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс хамтран Авлигатай тэмцэх газраас Ёс зүйн дэд хорооны дүрэм шинэчлэн батлуулахад санал тусгуулахаар дүрмийн төсөлд санал авч, 2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн А/98 дугаар газрын даргын тушаалаар байгууллагын ёс зүйн дүрмийг баталсан. 2025 онд 10 гомдол хүлээж авсанаас 7 дүгнэлт гарж үүнээс 2 зөрчилтэй албан хаагч байна. Албан хаагч нарын нийтлэг гарсан алдаа дутагдлыг давтан гаргуулахгүй байх үүднээс зөвлөмж боловсруулан албан хаагч нарт хүргүүлсэн.	
4.	2.1.4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах	2025 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар батлагдсан төсөв 9,298,990.9 төгрөг байна. Үүнээс 9,221,614.4 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 77,376.8 төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Мөн 10,873,1 төгрөгийн өглөг 1,522,9 авлагатай ажиллаж байна. 2025 оны 07 дугаар сарын 22 өдрийн А/223 тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй нийт 37 нэр төрлийн 74 ширхэг 11,617,7 мянган төгрөгийн хангамжийн материалыг актлаж данс бүртгэлээс хасч, 2025 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/303 тоот тушаалаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийлүүлсэн 7 нэр төрлын 88,729,0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн данс бүртгэлд бүртгэн авсан. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллоготой холбоотой тушаал төлөвлөн 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 30-ны хооронд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	100
5.	2.1.5. Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1116 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрэмд байгууллагын үндсэн чиг үүргийг заасан ба НЭМГ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Албан хаагчийг шилжүүлэн томилох тухай” А/286 дугаар тушаалаар 110 орон тоог баталж байгуулсан.	100

	Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах	2025 оны байдлаар Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлөх тохиолдол гараагүй байна.	
6.	2.1.6.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа 6 байгууллагын 2025-2026 оны өвөлжилтийн үед хүндэрч болзошгүй ажлын саналыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/1024 тоот албан бичгээр Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу “20 минутын хот” концепцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НЭМГ-ын Ажлын хэсгийн гишүүдийг 2024 оны А/142 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд Нийслэлийн харьяа 28 байгууллагыг 14 хотын газрын зураг дээр байрлуулж, холбогдох саналыг НЗДТГ-т хүргүүлсэн. Баримт бичиг боловсруулах ажлын явц 80-тай байна. Тус онд “20 минутын хот” концепцийн Ажлын хэсгийн гишүүд ЭМЯ-ны Ажлын хэсэгтэй хамтарсан нийт 4 удаагийн уулзалт хурлыг зохион байгуулсан. Нийслэлийн эрүүл мэндийн салбарыг бүсчилсэн хөгжлөөр хөгжүүлэх зураглал, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах шатандаа явж байна.“20 минутын хот” концепцийг хэрэгжүүлэх асуудлаар 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын Г.Лувсанжамц гишүүнтэй уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Уулзалт хэлэлцүүлгээр Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах бүтэц, зохион байгуулалтын талаар НЭМГ-ын ажилчид, харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын удирдлагатай өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөвлөгөөний талаар хэлэлцсэн. Улсын Их хурлаас “20 минутын хот” хорооллын хилийн цэсийн зааг тодорхой болоогүй, нэг жилээр хойшлуулсан тул хүлээгдлийн байдалтай байна.	90
7.	2.1.7.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам,	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны "Эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэгтгэсэнтэй холбоотой авах зарим арга хэмжээ тухай" А/824 дүгээр захирамжийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төвийн бүртгэлтэй эд хөрөнгийг Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн балансаас балансад шилжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран тус дүүргийн УАУЭСК төв болон Хан-	100

	шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Уул дүүргийн “Богд-Уул” сувиллын эд хөрөнгийг тоолж бүртгэх ажлыг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүрэн дуусгасан. 2. Актлах шаардлагатай хөрөнгө болон балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг СХНЭ-ийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, заагдсан журмын дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн. УАУЭСК төвийг СХНЭ-ийн бүтцэд нэгтгэн холбоотой салбар эмнэлэг, сувиллын орон тоог СХНЭ –ийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн 2025 оны 08 дугаар тогтоолоор эмнэлгийн бүтцэд нэмж, орон тоог шинэчлэн баталсан. Мөн хоол үйлдвэрлэл, худалдаа эрхэлж байгаа аж 190 ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд Эрүүл ахуйн тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт бус хяналт хийж ажилласан.Тодруулбал: 1.НЗД-ын 2025 оны А/376 дугаар захирамжийн хүрээнд "УБ фүүд фестивал" Олон Улсын хоолны өдөрлөгт 2025 оны 04 дүгээр сарын 07-13-ны өдрүүдэд, 2.НЗД-ын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлтийг зохион байгуулах талаар авах арга зарим арга хэмжээний тухай” А/649 дүгээр захирамжийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр, 3.НЗД-ын 2023 оны “Хүн амын стратегийн хүнсний нөөцийг тогтвортой, тэнцвэртэй байлгах талаар авах арга хэмжээний тухай” А/1147 дугаар захирамжийн хүрээнд мах хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, ААН-ийн агуулахад 2025 оны 02 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд, 4.НЗД-ын 2025 оны “Хөрөнгө гаргах тухай” А/167 дугаар захирамжийг үндэслэн “Монгол” нүүдэлчин өвлийн фестивалийн бэлтгэл ажлыг хангуулах болон фестивалийн үеэр 2025 оны 02 дугаар сарын 13-22-ны өдрүүдэд тус тус хяналт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг хангуулан, мэргэжил арга зүйгээр ханган ажилласаны үр дүнд нийтийг хамарсан осол, хордлого, болзошгүй эрсдлээс сэргийлэн ажилласан.	
8.	2.1.8. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах	Тус газрын дүрмээр хүлээсэн чиг үүрэг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/495 дугаар Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан нийт 40 заалт бүхий үндсэн чиг үүрэгтэй ба хэлтэс хоорондоо давхардсан 12	90

		чиг үүрэгтэй. Эхний хагас жилийн байдлаар чиг үүргийн хэрэгжилт 80%-тай байна. Хуулийн хугацаанд хүргэгдэх гээд жилийн эцсийн байдлаар нэгтгэгдэж байна.	
9.	2.1.9.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны батлах, хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд 1 зорилго 4 зорилт 8 арга хэмжээ бүхий хөтөлбөр боловсруулан НЗДТГазрын харьяа Хүний хөгжлийн төвтэй хамтран доорх сургалтуудад хамрагдсан: 2025.02.07 Ёс зүйн дэд хороодын гишүүдэд зориулсан цахим сургалтад байгууллагын Ёс зүйн дэд хорооны 7 гишүүдийг, 2025.03.21 Албан хэргийг хос бичгээр хөтлөх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх сургалтад 5 албан хаагч, 2025.03.25 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй сургалтад 2 албан хаагчийг, 2025.03.25 Гамшгийн үеийн бэлэн байдлын өмнөх бэлтгэл бэлэн байдлыг хангах болон ямар арга хэмжээ авах талаар 339, 400 дугаар тушаал, 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар сургалтад 42 албан хаагчийг, 2025.04.10 Процессийн дахин инженерчлэл, захиргааны шинэчлэл сургалтад 6 албан хаагчийг, 2025.04.18 Төрийн албанд хөтлөгддөг нийтлэг баримт бичиг сургалтад 4 албан хаагчийг, 2025.04.22 Төслийн удирдлагын үндэс сургалтад 7 албан хаагчийг, 2025.04.23 Төрийн албан хаагчийн ёс зүй сургалтад 55 албан хаагчийг, 2025.06.09 Архив, албан хэрэг хөтлөлт, edoc систем ашиглалт сургалтад 31 албан хаагчийг, 2025.09.16 ТАХ-ын ёс зүйн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сургалтад 1 албан хаагчийг, 2025.10.06-18-ны өдрүүдэд Аюулгүй, уур амьсгалд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн байгууллага, Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад 8 улсын /ахлах/ байцаагчийг, 2025.10.14Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал сургалтад 3 албан хаагчийг, 2025.10.03 Нийслэлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, арга зүй сургалтад 1 албан хаагчийг, 2025.10.17 МУЗГазрын 2025 оны 43 дугаар тотоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам сургалтад 1 албан хаагчийг, 2025.10.22 ERP системийн хэрэглээцахим сургалтад 40 албан хаагчийг, 2025.12.02 Авлига албан тушаалын хэргээс урьдчилан сэргийлэх нь сургалтад 40 албан хаагчийг, 2025.11.10 Засаглал, эрх зүйн хэлэлцүүлэгт 2 албан хаагчийг, Монгол бичгийн анхан шатны сургалтад 33 албан хаагчийг хамруулсан. “Менторшип хөтөлбөр”-ийг байгууллагын “Шинэ ажилтан чиглүүлэх хөтөлбөр”-тэй уялдуулан	100

		төлөвлөгөө гарган шинээр томилогдсон 3 албан хаагчийг төгсгөсөн. Зэрэг дэвийн нэмэгдэл ТЗ-30, ТҮ-11 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг сар бүр олгосон. 45 албан хаагчийг ЭХЭМҮТ эмнэлэгт үзлэг шинжилгээнд хамруулж ажилласан. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 92%-тай байна.	
10.	2.1.10. Албан хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах	Ёс зүйтэй төрийн албыг бий болгох, байгууллагын албан хаагчид хоорондын харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын Ёс зүйн хорооноос Ёс зүйн хорооны гишүүн М.Цэрэнбатыг урьж “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж 55 албан хаагчыг хамруулсан. Мөн Авлигатай тэмцэх газрын Ёс зүйн дэд хорооны дүрэм шинэчлэн батлуулах дүрмийн төсөлд санал авч, Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/98 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан. Нэгдүгээр улиралд тус хороо нь 3 гомдол хүлээж авсанҮүнтэй холбоотой гаргасан алдаа дутагдлыг давтан гаргуулахгүй байх зорилгоор сургалтын удирдамж боловсруулан ажиллаж байна.	100
11.	2.1.11.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг сайжруулах ажлын хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн прокурорын газартай хамтарсан сургалтыг 1 удаа, дотоод сургалтыг 10 удаа, хуулийн этгээд, иргэдэд 25 удаагийн сургалт зохион байгуулж, сурталчилан ажилласан. Иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дэвтэр буюу “Цагаан дэвтэр”-ийг Эрүүл мэндийн хөгжлийн төв, е-Монголиа академитэй хамтран бүрэн цахимжуулсан. Мөн тус газарт хандсан 1423 өргөдөл гомдол, хүсэлтээс 1372 гомдол, хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, 51 гомдол, хүсэлтийг судлах шатанд явж байна. Шийдвэрлэлтийн явц 96%-тай байна. 2025 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт ирүүлсэн байгууллагаас шаардлага хангасан 153 эмнэлэг, 121 Эмийн сан, 3 АШМУХҮ-д тусгай зөвшөөрлийг олгож, 52 эмнэлэгт чиглэл нэмж, 8 эмнэлэгийн чиглэлийг хасаж, 1 эмнэлэг болон 8	100

		эмийн сан, АШМУХҮ-1 тусгай зөвшөөрлийг сэргээж, 3 эмнэлэг, 21 хэрэгжилтийг хангуулан ажилласан. Шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 277, тусгай зөвшөөрлийн сунгалт хийлэх 702, ажлын байрны дүгнэлт гаргах болон эзэмшигч солих 212 нийт 1191 хуулийн этгээдэд хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулан ажилласан. Мөн 1 АШМУХҮ-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 1 эмнэлэг, 35 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоод байна. 159 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгож, ubhealth программд бүртгэсэн. Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтийн дагуу ажлын байранд дүгнэлт гаргах Ажлын хэсгийн багийг НЭМГ-ын даргын тушаалаар томилж_нийт 702 (эмийн сан 436, эмнэлэг 266) хуулийн этгээдийн зөвшөөрлийг сунгаж, ажлын байр шилжин байршсан 212 (эмийн сан 145, эмнэлэг 67), эмийн сангийн эрхлэгч солих 227 хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, нийт 1141 хуулийн этгээдэд хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулан ажилласан.	
12.	2.1.12.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх	Нийслэлийн архивын газрын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн байгууллагуудын архив, албан хэрэг, хөтлөлтийн үйл ажиллагаанд урьдчилсан үзлэг явуулах удирдамж, НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас тус газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан. ЭМХХ-ийн Улсын (ахлах) байцаагчдын үйлдсэн бичиг баримт бүхий 83 ботийг холбогдох стандартад нийцүүлсэн.	100
13.	2.1.13. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах	Хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагад хамаарах 6 индексийн үзүүлэлтийг сайжруулан ажиллаж байна. Тухайлбал: Индекс-66 буюу эрүүл мэндийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын чиглэлээр тус газраас Нийслэлийн хэмжээнд 2025 онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулалтын 13 томоохон ажил хийгдэж байна. Индекс-46 буюу нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр эрүүл мэндийн дэмжих төвийг 8 дүүрэгт байгуулсан. индекс-44 буюу эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт болон чанарын үзүүлэлтийг сар бүр тооцон гаргаж дүн шинжилгээ хийж ажилладаг ба 2025 оны жилийн эцсийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг 2026 оны 1 дүгээр улиралд эцэслэн гаргана.	100

		Индекс-2 буюу төрөлтийн түвшин. Тус газраас 2025 онд “Эхээс урагт дамжих гурвалсан халдвар”-ыг бууруулах, ургийн гажгийг эрт илрүүлэх боломжийг бүрдүүлэх, жирэмсний эрт хяналтыг нэмэгдүүлэх зэрэг 4 томоохон арга хэмжээг хийж хэрэгжүүлж байна.	
14.	2.1.14. Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох	Хотын хөгжлийн индексийн хэрэглээг нэвтрүүлэх, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах, олрон нийтэд нээлттэй статистик мэдээллийг гаргаж, Dijital city Dashboard багийн ажлын хэсэгт 2025 оны 1 дүгээр сарын 16, 20-ны өдөр тус тус хүргүүлсэн. Үүнд: 2023-2024 оны төрөлтийн мэдээ: - Амьд төрөлт, - Амьгүй төрөлт, - Төрсөн сараар, - Дүүргээр - Насны бүлгээр, 2023-2024 оны нас баралтын тоон мэдээ: - Насны бүлгээр, - Хүйсээр, - Нас барсан сараар - Дүүргээр - Амбулаторийн өвчлөл, - Стационарын өвчлөл тус тус гарган хүргүүлсэн. Нийслэлийн хүн амын өвчлөл, нас баралтын статистик мэдээллийг сар бүр нэгтгэн гаргаж, Нийслэлийн статистикийн газарт хүргүүлж, мэдээний санд оруулж байна.	100
15.	2.1.15. Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/02, 10-00/05, 10/00/11, 10-00/13 дугаартай удирдамжийн хүрээнд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 670 объект зарлагдсанаас 662 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 98.8%-ийг хамрууллаа. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, татан буугдсан объект 1.2%-ийг эзэлж байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад 3367 зөрчил, дутагдал илрүүлэн, 2041 буюу 71%-ийг арилгуулан, улсын (ахлах) байцаагчийн 1939 заалт бүхий 324 албан шаардлага хүргүүлэн, 59 дүгнэлт, 13 зөвлөмж гарган, 52 аж ахуй нэгж, байгууллага, иргэнд 64.950.000 төгрөгийн шийтгэл ногдуулан, 52 аж нэгж, байгууллага, иргэнд эрхий бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлэн ажиллаж, 66 объектод гүйцэтгэлийн хяналт шалгалтаар биелэлтийг тооцож ажиллав. Хяналт шалгалтын дүнг тус газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ЭМЯ-нд хүргүүлэв. Төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, баталгаажуулах хяналт шалгалтаар	100

		12037 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 2214 зөрчил, дутагдал илрүүлэн, 1549 буюу 70%-ийг арилгуулан 252 албан шаардлага, 436 дүгнэлт, 54 зөвлөмж гарган, 152 хуулийн этгээд, иргэнд 241.870.500 төгрөгийн шийтгэл ногдуулан ,нийтийг хамарсан хордлого ,хордлогот халдвараас сэргийлэн ажилласан. Хяналт шалгалтын дүнг хэлтсийн удирдлагад танилцуулан, танилцуулга, илтгэх хуудсуудыг тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлэн, зөвлөмж мэдээллийг тус газрын цахим хуудаст 22 удаа байршуулсан байна.	
16.	2.1.16. Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх	1.Эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах хүрээнд 0-18 насны хүүхдийн эмнэлгийн бус эндэгдлийг судлах ажлыг 2024 оны 11 дүгээр сараас эхлүүлсэн. Мэдээг тухай бүр авдаг бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 03-ны хугацаанд нийт 75 тохиолдол бүртгэгдсэн ба шалтгаанаар авч үзвэл осол, гэмтэл-32%, гэнэтийн нас баралт 28%, өвчний шалтгаант 29,3%, угаарын хордлого 6,7%, амиа хорлолт 4%-ийг тус тус эзэлж байна. 2.Мөн эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах хүрээнд 2025 оны 03 сарын 01-ний өдрөөс эмэгтэйчүүдийн үр хөндөлтийн шалтгаан, хүчин зүйлийг асуумжийн аргаар иргэдээс авах судалгааг хийж байна. 3.Нийслэлийн Түргэн тусламжийн төв үүсгэн байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус төвөөс 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Эрдмийн чуулган - 2025” арга хэмжээг 2 үе шаттай зохион байгуулсан. 4.Нийслэлийн Өргөө амаржих газраас “Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг сайжруулах арга замууд” сэдэвт Олон Улсын Эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. 5. НЭМГ-ын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/277 дугаар тушаалын дагуу “Сайн туршлага-2025” арга хэмжээг 2 хэсгээр 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Эрүүл мэндийн чанарын холбоотой хамтран зохион байгуулж, “Ховор тохиолдлын хэлэлцүүлэг-2025” арга хэмжээний эхний хэсэг “Ховор тохиолдлын хэлэлцүүлэг”-ийг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Хан Туул Хүүхдийн Сэргээн засах төвийн байранд 2025 оны хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тохиолдсон ховор тохиолдлыг хэлэлцүүлж, аман болон ханан төрлөөр шилдэг илтгэлүүдийг тодруулсан болно.	90
17.	2.1.17. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн 2025 оны жилийн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.	100

	гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах	Тус газарт хандсан 1423 өргөдөл гомдол хүсэлтээс 1372 гомдол, хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, судлаж шийдвэрлэх шатанд 51 гомдол, хүсэлт байна. Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ 961 гомдлыг иргэний талд, 410 өргөдөлд боломжгүй тухай хариу өгсөн бөгөөд албан бичгээр 370, утсаар-788, 102 иргэнд мессеж буюу цахим харилцаагаар хариуг хүргүүлж 112 иргэнтэй биечлэн уулзаж шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдлын хандалтаас үзэхэд, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, ӨЭМТ болон эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, тамхины тусгай зөвшөөрлийн ажлын байрны дүгнэлт гаргуулах, орон сууцны 1 дүгээр давхарт байрлах үйлчилгээний газрууд, хоолны газар, баар рестораны үйлчилгээ, эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналт, нийтийн эзэмшлийн гудамж, ил задгай худалдаа, үйлчилгээ, хүнсний чанар, аюулгүй байдлын хяналт, эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, яаралтай тусламж, үйлчилгээ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн салбарын цалин, хөлс, төрийн албан хаагчийн ёс зүй, хог хаягдал шатаах, орчны эвгүй үнэр, агаарын бохирдолтой холбоотой гомдол нийт гомдлын 88.6%-ийг эзэлж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хоног 2024 оны мөн үетэй харьцуулахад дундаж хугацаа 12 хоног 10 цаг 46 минут байсан бол 2025 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар 11 хоног 12 цаг 13 минут болж буурсан үзүүлэлттэй байна. 2025 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар 96 хувьтай шийдвэрлээд байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад (93%) шийдвэрлэлт 3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг (3-р улирал) байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулан ажилласан.	
18.	2.1.18.Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас 2025 оны 01 сарын 13-ны өдрөөс хойш нийт 23 удаагийн шуурхай хуралдааны 88 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр хангаж НЗДТГ-т тайлагнасан. 2024 оны шуурхай хуралдааны үүрэг даалгаврын нэгтгэл, 2025 оны шуурхай хуралдааны нэгтгэл биелэлтийг 2025 оны 10 дугаар 28-ны өдөр НЗДТГ-т хавсралтаар хүргүүлсэн.	100

		Тус газарт 2025 оны 12 сарын 03-ны байдлаар нийт 8123 албан бичиг ирсэн байна. Үүнээс 408 хариутай бичгийн 336 албан бичгийг нь хугацаанд нь шийдвэрлэж хугацаа сунгуулсан 12 бичиг байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 59 албан бичгийн зөрчилтэй байна. 7715 хариугүй албан бичгээс 7491 бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн бусад судлах шатандаа байна. Ирсэн албан бичгийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад албан бичгийн тоо 30.8 хувиар нэмэгдсэн байна. НЗДТГ-аас 01 дугаартай Албан даалгавар, “Чиглэл хүргүүлэх тухай” 13 албан бичиг ирснээс 12 албан бичгийг журмын дагуу хугацаанд шийдвэрлэж, нийслэлийн удирдлагуудаас өгсөн албан даалгавар, чиглэлийг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн харьяа байгууллагын 14 хоногийн шуурхай хуралдаанаар шийдвэрлэлтийн явц, хэрэгжилтийг хянан ажиллаж байна. НЗД-аас өгсөн үүрэг даалгаврын дагуу НЭМГ, УСУГ-тай хамтран “Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, шинэ цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалт” сэдвийн хүрээнд Нийслэлийн харьяа бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудтай уулзалт, түүний үр дүнгийн талаарх тайланг НЗДТГ-т 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 02/2271 дүгээр бичгээр хүргүүлсэн. МУ-ын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг нотлох баримтын хамт НЗДТГ-т 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2786 дугаар бичгээр хүргүүлсэн.	
19.	2.1.19. Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах	“Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд бодлогын зорилт 23, хуулиар олгосон чиг үүрэг 20, дүрмээр хүлээсэн чиг үүрэг 13, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 6 нийт 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, 2025 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн дундаж 94.05%-тай байна. Жилийн эцсийн байдлаар 94,86%-тай хэрэгжсэн байна.	100
20.	2.1.20. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд	Байгууллагын 2025 оны зорилго, зорилтод нийцүүлсэн нийт 62 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байршуулсан. Түүнчлэн иргэд аж ахуйн нэгжтэй уулзах хуваарь, иргэдийн өргөдөл гомдол, албан бичиг хүлээн авах ажилтны нэр, холбоо барих хаяг, тусгай зөвшөөрөл, хүний нөөцийн мэдээлэл,	90

	холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх	төсөв санхүү зэрэг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудаст дэлгэрэнгүй байршуулсан. UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст Нийслэлийн Засаг даргын захирамж, цаг үеийн мэдээ, мэдээлэл, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэгтэй холбоотой тушаал, шийдвэрийг цаг тухай бүр нь байршуулдаг ба байгууллагын цахим хуудасны “Онлайн тайлан”, “Тусгай зөвшөөрөл” цэст мэдээллийг тогтмол баяжуулан ажиллаж байна.	
21	2.1.21.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах	Шилэн дансны нэгдсэн системд 2025 оны 12 дугаар сарын байдлаар 171 мэдээлэл байршуулахаас мэдээлэл оруулах хугацаа болоогүй 22, хугацаандаа мэдээлсэн 140, хугацаа хоцорч мэдээлсэн 5, мэдээллээгүй 4 нийт 149 мэдээг байршуулсан байна. Үүнээс төсөв гүйцэтгэлтэй холбоотой 56, хөрөнгө оруулалт 32, бусад 61 мэдээлэл байна. Байгууллагын цахим сайтад шилэн дансны https://shilendans.gov.mn/organization холбоосоор дамжин байгууллагын санхүүгийн ил тод байдалтай танилцах боломжийг бүрдүүлж ажилласан.	100
22	2.1.22.Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах	Тус байгууллагын гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа болон бусад арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт мэдэгдэж, холбогдох Гадаад харилцааны сайдын тушаал, тус газрын журам, бодлогын баримтыг дагуу хэрэгжүүлж ажилладаг. 2025 оны жилийн эцсийн байдлаар дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: ➢ 7 сард БНХАУ-ын Гуандун Бу Ай групп, ➢ 8 сард БНСУ-ын Хьюсаранг групп, ➢ 9 сард БНКазУ-ын Олон улсын магадлан итгэмжлэлийн төв (ACQH) ➢ 10 сард Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль гээд нийт 4 байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан. Харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын давхардсан тоогоор 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой урт болон богино хугацааны сургалтад хамруулах, харилцан туршлага солилцох, хамтарсан судалгаа хийх, олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлж оролцох чиглэлээр хамтран ажилласан. Мөн байгууллага болон салбарын хүрээнд зохион байгуулсан зөвлөгөөн, хуралдаан нийт 4 байна. Үүнд: ➢ 4 сард Цахим эрүүл мэнд зөвлөгөөн	100

		➤ 6 сард Эрүүл монгол хүн зөвлөгөөн ➤ 8 сард Нугалмын байршлын эмгэг ба сколиозын эсрэг хамтдаа Олон улсын эрдэм шинжилгээний онол-практикийн хурал ➤ 9 сард Worldwide network for blood and marrow transplantation nurses and doctors' workshop хурал зохион байгуулагдаж, гадаад, хамтын ажиллагаагаа бэхжүүлэн ажилласан байна.	
23	2.1.23 Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх	НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй хамтарч цаг үеийн байдалтай холбогдуулан дараах видео зөвлөмж бэлтгэж хүргэсэн. Үүнд: 1.“Эх, үрсийн баяр”-тай холбоотой “Монгол хүүхдүүд 2025” аяны хүрээнд НЭМГ-аас 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хоол хүнстэй холбоотой зөвлөмжийг хүргүүлж ажилласан. 2.Эрүүл мэндийн чиглэлээр 8 удаагийн мэдээ, мэдээллийг НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээр хүргүүлэн түгээсэн байна. Үүнд: 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр “Ханиад, томууны үед дархлаагаа дэмжих”, 2025 оны 11 дүгээр 24-ний өдөр “Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүд ажлын өдөр 20:00 цаг хүртэл уртасгасан цагаар ажиллах”, 2025 оны 10 дугаар 20-ны өдөр “Нийслэлийн ор дэлгэлтийн мэдээлэл”, “Томуу, томуу төст өвчний удьдчилан сэргийлэх дархлаажуулалт”, 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр “Эрүүл мэндийн салбарын төсөл хөтөлбөр”, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Баянзүрх дүүргийн ахмадын эмнэлгийн нээлтийн үйл ажиллагаа”, 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр “Улаанбурхан гэж юу вэ?”, “Улаанбурхан өвчнөөс сэргийлье”, “Маскаа зүүе аян”, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр “Сувилахуйн тусламж үйлчилгээг танилцуулах өдөрлөг”, 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “9 дүүргийн эрүүл мэндийн төвд маск хандивласан” гэх мэдээллүүдийг хүргэсэн.	100
24	2.1.24.Нийслэлийн Засаг даргын "2025 оныг Бүтээн байгуулалтын жил болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийн дагуу бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудаас дурдвал: 1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг 2025 онд нийт төсөвт өртөг нь 6.5 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/566 дугаар захирамжаар эрх шилжсэн Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Сонгинохайрхан дүүргийн худалдан авах ажиллагааны алба зохион байгуулсан. Тендер шалгаруулалтаар уг барилгын ажлыг 6.3 тэрбум	100

	төгрөгөөр гүйцэтгэхээр Вайтфиникс ХХК шалгарч гэрээ байгуулсан. 2.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн цогцолбор барилгын ажлыг 2022-2026 онд нийт төсөвт өртөг нь 13.1 тэрбум төгрөгийг төсөвлөсөн.Тус барилгын ажлыг гүйцэтгэхээр "Содон номин констракшн" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын бетон цутгалт хийгдэж, ханын блокон дүүргэлтийн өрлөгийн ажил үргэлжилж байна. 3.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Аддиктологийн төвийн хуучин барилгыг буулгаж, шинээр барих ажлыг 2022-2026 онд нийт төсөвт өртөг нь 39.8 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар Аддиктологийн төвийн барилгын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Уг тендерт “Бүрэн Одод” ХХК нь шалгарч 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулж, хуучин барилгын ажлыг буулгаж, буулгалтын ажил хийгдсэн. Гадна, дотор талын өрлөгийн ажил, гадна фасадны дулаалгын ажил үргэлжилж байна. Барилгын цонх суулгалтын ажил хийгдэж дууссан. Барилгын явц 50%-тай байна.	
Дундаж хэрэгжилтийн хувь		98.3%

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА

Н.НАРАНБААТАР